



LEGAL NEWSLETTER

2024 August №48

AKP Law Firm

Бид энэ оны 8 дугаар сард батлагдсан онцлох УИХ-ын болон Засгийн Газрын тогтоол, соёрхон баталсан МУОУГэрээ, Аймаг нийслэлийн ИТХ-ын шийдвэрийг танилцуулж байна.

Энэ сард шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль байхгүй.

I. УИХ-ЫН ТОГТООЛ:

2024 оны 8 дугаар сард нийт 15 УИХ-ын тогтоол батлагдсан ба Байнгын хорооны дарга нарыг томилох, чөлөөлөх, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай дийлэнх нь байв. Үүнээс бид дараах тогтоолыг онцоллоо.

1.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА СОЛИГДОВ

- ✓ Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлж, Барсүрэнгийн Баасандоржийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилов.
- ✓ УИХ-ын Байнгын хороо нарын дарга нарыг сонгов:

УИХ-ын Байнгын хороо	Дарга
1/Аж үйлдвэржилтийн бодлогын	Сайнхүүгийн Ганбаатар
2/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн	Буланы Бейсен
3/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын	Чинбатын Ундрэм
4/Ёс зүй, дэгийн	Баярмагнайн Баярбаатар
5/Инновац, цахим бодлогын	Жаргалсайханы Золжаргал
6/Нийгмийн бодлогын	Лутаагийн Энхнасан
7/Эдийн засгийн	Ренчинбямбын Сэддорж
8/Аюулгүй байдал, гадаад бодлогын	Ганзоригийн Тэмүүлэн
9/Төрийн байгуулалтын	Жадамбын Бат-Эрдэнэ
10/Төсвийн	Цэрэнпилийн Даваасүрэн
11/Хууль зүйн	Дамдины Цогтбаатар

- ✓ Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлагдав.

Нэмэгдсэн өөрчлөлтүүд:

(+)МУ-ын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд



(+)Оюуны өмчийн газар /ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг/

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд



(+)Хөрөнгө оруулалт худалдааны газар,
(+)Монополын эсрэг газар /ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг/

(+)Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд



(+)Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар

(+)Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд

II. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлав:

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Эрүүл мэндийн яам
- Боловсролын яам
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
- Батлан хамгаалах яам

III. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын баталсан "Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц"

Конвенцийг Монгол, Англи хэлээр унших холбоос:



2. "Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц" BEPS

Конвенцийг Монгол, Англи хэлээр унших холбоос:



3. "Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралт"

Конвенцийг Монгол, Англи хэлээр унших холбоос:



4. Европын зөвлөлөөс баталсан Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенц

Конвенцийг Монгол, Англи хэлээр унших холбоос:



5. "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА /Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенц

Конвенцийг Монгол, Англи хэлээр унших холбоос:



IV. САЙДЫН ТУШААЛ:

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам" батлагдав.
- Боловсролын Ерөнхий Хууль 3.1.23 "эндаументын сан" гэж дээд боловсролын сургалтын байгууллагад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ашиг олох зорилгогүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгийг хэлнэ.

Дээрх агуулгатай холбоотой бусад дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар илгээнэ үү.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5-р хороо, Pearl tower A блок 902 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 9511-3680